Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч, Засаг дарга Ж.Дамдинбазар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил Булган аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн ОНХС-гийн хөрөнгийг батлуулж зарцуулахдаа Сангийн сайдын холбогдох журмуудыг зөрчдөг байдлыг таслан зогсоох, орлогын бүртгэл, анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 21-нээс 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга нар гүйцэтгэв.

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 3/96 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган сумын засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, тэдний бие бялдар, сэтгэл зүйн сайн сайхан байдлыг хамгаалах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэх
- Төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчныг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлэх олон талт үйл ажиллагаа явуулах

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Булган сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ховд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүү, дотоод аудитын албанаас 2020 онд Булган сумын ТТЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Булган сумын ТТЗ-ын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшнийг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Энэ нь материаллаг байдлыг үнэ цэнэ талаас нь авч үзэхийн тулд санхүүгийн тайлангийн хамгийн чухал хэсгүүд болох нийт орлогыг /өөрийн орлого, төсвийн санхүүжилт, татвар болон татварын бус орлог/-ыг сонгон авч үзлээ.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаас тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн нийт орлогын 10269454.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож 102694.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон болно.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 173981.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 231539.7 мянган төгрөг болж 75080.9 мянган төгрөгөөр буюу 33.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1: Мөнгөн хөрөнгө* *мянган төгрөг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дунд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Минжит булган ОНӨААТҮГ | 13205.7 | 4444.3 | 8761.4 | 1.9 |
| СХС | 2352.5 | 16646 | 14293.5 | 7.2 |
| Төрийн сан | 158423.4 | 210449.4 | 52026 | 90.9 |
| **Дүн** | **173981.6** | **231539.7** | **75080.9** | **100** |

*Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 231539.7 мянган төгрөгөөс 227095.4 мянган төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 4444.3 мянган төгрөг нь арилжааны банкны харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө байна. Арилжааны банканд багаа мөнгөн хөрөнгө нь "Минжит булган" ОНӨААТҮГ-ын харилцах дансны үлдэгдэл байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 555237.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 656463.6 мянган төгрөг болж 101226.3 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл* *мянган төгрөг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 10,727.1 | 7,629.2 | (3,097.9) |
| Байгууллагаас авах авлага | 1,201.3 | 119,869.0 | 118,667.7 |
| Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага | 543,308.9 | 528,965.4 | (14,343.5) |
| **Дүн** | **555,237.3** | **656,463.6** | **101,226.3** |

*Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 528965.4 мянган төгрөгийн дараах авлага байна.

*Нийт авлагын 80.6 хувийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 543308.9 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант 39050.0 мянган төгрөгийн зээл олгож, 53343.5 мянган төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 528965.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.*

*Сум хөгжүүлэх сангаас 2016-2019 онуудад олгосон 59 зээлдэгчийн 289500.0 мянган төгрөгийн зээлийн авлага нь хэвийн төлөгдөж, 2011-2016 онуудад олгосон 98 иргэнтэй холбогдох 159465.4 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлага сангийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна. Тухайн хугацаа хэтэрсэн 98 иргэнтэй холбогдох авлагыг 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр шүүх, хяналтын байгууллагад шилжүүлж ажилласан байна.*

*Байгууллагаас авах авлага нийт авлагын 18.2 хувийг байгууллагаас авах авлаг эзэлж байгаа нь ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлуудын санхүүжилтийг 12 сард гаргасантай холбоотойгоор 110900.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.*

*Аудитын илрүүлэлт:*

*- СХС-гийн зээлийн авлагыг санхүүгийн тайланд 74049.6 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн*

*- СХС-гийн тайланд бүртгэлтэй малжуулах зээлийн авлагыг харилцагч бүрээр гаргаж тооцоо нийлж баталгаажуулаагүй*

*- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлуудын санхүүжилтийг 12 сард гаргасантай холбоотойгоор хөрөнгө оруулалтын ажлууд нь хийгдээгүй байна.*

### 3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 15000.0 мянган төгрөг болж өмнөх оноос 15000.0 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 3: Урьдчилгаа дансны үлдэгдэл* *мянган төгрөг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|

| | | |
|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | **15000.0** | **15000.0** |
| Бараа материал бэлтгэх урьдчилгаа | | |
| **Дүн** | **15000.0** | **15000.0** |

*сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй 15000.0 мянган төгрөг нь тайлант онд ЗДТГ нь киноны зохиолын урьдчилгаа хөрөнгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 338989.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 336913.3 мянган төгрөг болж 2075.9 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 4: Бараа материалын үлдэгдэл* *мянган төгрөг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалтын материал | 5,345.6 | 6,174.5 | 828.9 |
| Эм боох материал | 414.0 | 4,773.9 | 4,359.9 |
| Бичиг хэргийн материал | 34,522.4 | 27,721.0 | (6,801.4) |
| Аж ахуйн материал | 96,369.5 | 88,453.8 | (7,915.7) |
| Сэлбэг хэрэгсэл | | 2,040.0 | 2,040.0 |
| Түлш, шатах тослох материал | 49,354.8 | 71,724.3 | 22,369.5 |
| Барилгын засварын материал | 1,670.2 | 1,412.7 | (257.5) |
| Хүнсний материал | 57,850.0 | 40,409.4 | (17,440.6) |
| Бусад хангамжийн материал | 92,142.7 | 92,883.7 | 741.0 |
| Мал амьтад | 1,320.0 | 1,320.0 | - |
| **Дүн** | **338,989.2** | **336,913.3** | **(2,075.9)** |

*Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Бараа материал 2075.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 451662.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч үнэ төлбөргүй 10003,3 мянган төгрөгийн бараа материал орлогод авч нийт 461665.5 мянган төгрөгөөр бараа материал нэмэгдэж 454617.8 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулж 91236. Мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 11396185.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 15491277.6 мянган төгрөг болж 4095092.5 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 5: Үндсэн хөрөнгийн үлдэгдэл* *мянган төгрөг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 7,067,801.2 | 10,760,773.6 | 3,692,972.4 |
| Тээврийн хэрэгсэл | 519,387.4 | 594,337.4 | 74,950.0 |
| Машин тоног төхөөрөмж | 955,400.7 | 1,060,217.7 | 104,817.0 |
| Тавилга эд хогшил | 773,455.9 | 896,061.9 | 122,606.0 |
| Зам гүүрний барилга байгууламж | 38,859.8 | 38,859.8 | - |
| Түүх соёлын дурсгалт зүйл | 2,340.6 | 2,340.6 | - |
| Дуусаагүй барилга байгууламж | 59,990.0 | 65,217.2 | 5,227.2 |
| Номын фонд | 134,526.5 | 144,376.6 | 9,850.1 |
| Бусад үндсэн хөрөнгө | 1,470,594.3 | 1,554,014.1 | 83,419.8 |
| Программ хангамж | 4,495.0 | 5,745.0 | 1,250.0 |
| Бусад биет бус хөрөнгө | 369,333.7 | 369,333.7 | - |
| **Дүн** | **11,396,185.1** | **15,491,277.6** | **4,095,092.5** |

*Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 38560.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандив, хөрөнгө оруулалтаар авсан 4201430.8 мянган төгрөгөөр нэмэгдэж

Сумын ИТХ-ын тогтоолоор 20208.2 мянган төгрөгийн номыг 2-р сургууль данснаас хасаж ЗДТГ нь дуусаагүй барилгад бүртгэлтэй явган хүний замын ажлыг тайлант онд хүлээн авч 59990.0 мянган төгрөгөөр бууруулсан, мөн ЗДТГ нь 30000 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар зарахаар аймгийн Өмчийн газарт өгч нийт 110198.2 мянган төгрөгөөр хөрөнгө хасагдсантай холбоотой байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 12502.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 228.1 мянган төгрөг болж 12274.2 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 6: Өр төлбөрийн үлдэгдэл* *мянган төгрөг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **Богино хугацаат өр төлбөр дүн** | | | | |
| Ажиллагсадтай холбогдсон өр | 1188.1 | 20.5 | -1167.6 | 9.0 |
| Байгууллагад төлөх өглөг | 11314.2 | 207.6 | -11106.6 | 91.0 |
| **Нийт дүн** | **12502.3** | **228.1** | -12274.2 | **100** |

*Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 228.1 мянган төгрөгийн өр байгаа нь Булган спорт цогцолборын өр бөгөөд энэ нь тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүйгээр бага дүнтэй байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 9489575.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 13165913.6 мянган төгрөг болж 3676338.4 мянган төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт 7: Засгийн газрын хувь оролцоо* *мянган төгрөг*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | | | |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 4,439,254.9 | 4,439,254.9 | - | 33.7 |
| Хуримтлагдсан үр дүн | 1,072,537.1 | 4,748,875.5 | 3,676,338.4 | 36.1 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,977,783.2 | 3,977,783.2 | - | 30.2 |
| **Дүн** | **9,489,575.2** | **13,165,913.6** | **3,676,338.4** | **100.0** |

Хуримтлагдсан үр дүн данс нь 3676338.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр 3676338.4 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Өмнөх оны хуримтлагдсан үр дүнд залруулах бичилт хийгдээгүй байна.

### 3.5.10 Орлогын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 10269454.6 мянган төгрөг болж өмнөх оноос 3789258.5 мянган төгрөгөөр буюу 58.5 хувиар өссөн байна.

Өссөн 3789258.5 мянган төгрөгийн орлогоос материаллаг өөрчлөлт орсон татварын орлого 72455.8 мянган төгрөгөөр буюу 39.0 хувиар, торгуулийн орлого 30698.4 мянган төгрөг буюу 41.4 хувиар, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 3610186.6 мянган төгрөгөөр буюу 840.9 хувиар, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 549691.6 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар, үндсэн үйл ажиллагааны орлого 5432.0 мянган төгрөгөөр буюу 65.6 хувиар хувиар, нэмэлт санхүүжилтийн орлого 147708.1 мянган төгрөгөөр буюу 106.4 хувиар

нэмэгдэж туслах үйл ажиллагааны орлого 571.4 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар, бусад орлого 4095.4 мянган төгрөгөөр буюу 100 хувиар, орон нутгийн төсвөөс санхүүжигдэх орлого 641505.8 мянган төгрөгөөр 35.1 хувиар тус тус буурсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Орон нутгийн татварын орлогын биелэлтэд санхүүгийн албаны дарга хяналт тавиагүй хэдэн төгрөгийн орлого орохоос хэдэн төгрөгийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн талаарх мэдээллийг аудитад гаргаж өгөөгүй болно*

### 3.5.11 Зардлын данс

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 6572908.1 мянган төгрөг болж өмнөх оноос 124908.1 мянган төгрөг буюу 2 хувиар буурсан байна.

Буурсан 124908.1 мянган төгрөгийн зардлаас материаллаг өөрчлөлт гарсан дараах зардлууд байна. Үүнд: Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 574212.1 мянган төгрөгөөр буюу 17.2 хувиар, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 84539.6 мянган төгрөгөөр буюу 20.3 хувиар, тогтмол зардал 12788.0 мянган төгрөгөөр буюу 5 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 285254.1 мянган төгрөгөөр буюу 48.74 хувиар, эд хогшил урсгал засварын зардал 7432.2 мянган төгрөгөөр буюу 87.6 хувиар тус тус нэмэгдэн хангамж бараа материалын зардал 100816.7 мянган төгрөгөөр буюу 18.7 хувиар, нормативд зардал 135828.0 мянган төгрөгөөр буюу 45.1 хувиар, томилолтын зардал 11834.8 мянган төгрөгөөр буюу 63.1 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр 14399.7 мянган төгрөгөөр буюу 39.6 хувиар, урсгал шилжүүлэг 576438.8 мянган төгрөгөөр буюу 60.6 хувиар буурсан байна. Зардал буурах болсон шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сургууль, цэцэрлэг, соёлын төвийн үйл ажиллагааг хязгаарласантай холбоотой байна.

Зардлын данстай холбоотой 77286.1 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

*Аудитын илрүүлэлт:*

- *Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалын 3.11.3-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх” гэсэн заалтыг зөрчин ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд нь батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй байхад ИТХ-аар оруулан батлуулсан. 3.1.4-д “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах” гэсэн заалтыг зөрчин иргэдийн санал аваагүй арга хэмжээг ИТХ-аар оруулан батлуулж санхүүжүүлжээ. Үүнд*
- *ОНХС-гаас эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг зохин байгуулахад 5000.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн.*
- *ОНХС-гаас ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулахад 6286.5 мянган төгрөгийг санхүүжүүлсэн.*
- *ОНХС-гийн хөрөнгөөр сумын залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулахтай холбоотой 4000.0 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн.*
- *ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 50000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлж хүлээн авсан боловч ЗДТГ-т хөрөнгийг орлогод бүртгээгүй байна.*
- *ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн Лед дэлгэц худалдан авахад 12000.0 мянган төгрөгийн зарцуулсан боловч шууд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан.*
- *И баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн.*

### 3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт**

Булган сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 2020 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 09/02 дугаар тогтоолд Булган сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 337969.8 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 432194.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 127.8 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт дугаар 8. Сумын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл* /төгрөг/

| Орлогын ангилал | 2020 оны | | Зөрүү |
|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| | **337,969,800.00** | **432,194,339.39** | **(94,224,539.39)** |
| **Нийт орлого ба тусламжийн дүн** | **337,969,800.00** | **432,194,339.39** | **(94,224,539.39)** |
| **Татварын орлого** | **184,869,800.00** | **257,640,198.39** | **(72,770,398.39)** |
| **Орлогын албан татвар** | **151,000,000.00** | **210,015,266.34** | **(59,015,266.34)** |
| **Хувь хүний орлогын албан татвар** | **151,000,000.00** | **210,015,266.34** | **(59,015,266.34)** |
| Хөрөнгийн орлого | 100,000,000.00 | 107,567,576.44 | **(7,567,576.44)** |
| Үйл ажиллагааны орлого | 9,000,000.00 | 6,741,000.00 | **2,259,000.00** |
| Шууд бус орлого | 42,000,000.00 | 95,706,689.90 | **(53,706,689.90)** |
| **Хөрөнгийн албан татвар** | **3,704,800.00** | **5,267,500.00** | **(1,562,700.00)** |
| Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | - | 3,210,000.00 | **(3,210,000.00)** |
| Бууны албан татвар | 3,704,800.00 | 2,057,500.00 | **1,647,300.00** |
| **Бусад татвар, төлбөр, хураамж** | **30,165,000.00** | **42,357,432.05** | **(12,192,432.05)** |
| **Бусад нийтлэг төлбөр, хураамж** | **20,490,000.00** | **32,665,405.05** | **(12,175,405.05)** |
| Улсын тэмдэгтийн хураамж | 13,230,000.00 | 25,254,405.00 | **(12,024,405.00)** |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 3,000,000.00 | 3,151,000.05 | **(151,000.05)** |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 4,260,000.00 | 4,260,000.00 | **-** |
| **Газрын төлбөр** | **-** | **538,814.00** | **(538,814.00)** |
| Газрын төлбөр | - | 538,814.00 | **(538,814.00)** |
| **Байгалийн нөөц ашигласны төлбөр** | **9,675,000.00** | **9,153,213.00** | **521,787.00** |
| Ой нөөц ашигласны төлбөр | | 761,013.00 | **(761,013.00)** |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 2,675,000.00 | 2,675,000.00 | **-** |
| Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 7,000,000.00 | 5,717,200.00 | **1,282,800.00** |
| **Татварын бус орлого** | **153,100,000.00** | **174,554,141.00** | **(21,454,141.00)** |
| **Нийтлэг татварын бус орлого** | **153,100,000.00** | **174,554,141.00** | **(21,454,141.00)** |
| Хувьцааны ногдол ашиг | | | **-** |
| Торгуулийн орлого | 65,000,000.00 | 104,793,870.00 | **(39,793,870.00)** |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 15,400,000.00 | 13,716,800.00 | **1,683,200.00** |
| Туслах үйл ажиллагааны орлого | 72,700,000.00 | 56,043,471.00 | **16,656,529.00** |

*Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Нийт орлого 432194.3 мянган төгрөг буюу 94224.5 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ. Орлого давсан шалтгаан нь хувь хүний орлогын албан татвар 59015.3, хөрөнгийн албан татварын орлого 1562.7, бусад татвар, төлбөр хураамж 12192.4, газрын төлбөрийн орлого 538.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлж байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого 521.8 мянган төгрөгөөр тасалжээ. Татварын орлого 42770.4 мянган төгрөгөөр давуулан биелүүлэхэд Эрдэнэс таван толгойн хувьцааны ногдол ашгаас хувь хүний орлогын албан татварт 54347.4 мянган төгрөг гол нөлөө үзүүлжээ. Татварын бус орлого 21454.1 мянган төгрөгөөр давсан нь торгуулийн орлого 39793.9 мянган төгрөгөөр давж сумын ЗДТГ нь өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан, СХС-гийн зээлийн эргэн төлөлтийн орлогыг тасалсантай холбоотой байна.

## Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6040715.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 6040715.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг сая 6040715.0 мянган төгрөгөөр баталсан байна.

## Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 6040715.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5354647.5 мянган төгрөгийг урсгал зардалд, 616067.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, эргэж төлөгдөх зээлийн зардалд 70000.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 4376564.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүжилтээс, 1088058.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 487991.6 мянган төгрөгийг ОНХС-аас, 88100.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

*Хүснэгт дугаар 9. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэл* */мянган төгрөг/*

| Д/д | Байгууллагын нэр | Нийт төлөвлөгөө | | | Гүйцэтгэл | | | Зөрүү | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Санхүүжилт | Өөрийн орлого | нийт | Санхүүжилт | өөрийн орлого | Нийт | | |
| 1 | ЗДТГ | 628,742.0 | 1,400.0 | 630,142.0 | 541,804.2 | 76.0 | 541,880.2 | (88,261.8) | Өөрийн орлогын төлөвлөгөө биелүүлээгүй Орон нутагт төвлөрүүлсэн |
| 2 | ИТХ | 71,247.2 | - | 71,247.2 | 70,030.7 | - | 70,030.7 | (1,216.5) | Төвлөрүүлсэн |
| 3 | Сум хөгжүүлэх сан | - | 70,000.0 | 70,000.0 | - | 53,343.5 | 53,343.5 | (16,656.5) | СХС зээлийн эргэн төлөлт төлөвлөгдсөн хэмжээнд бүрдээгүй |
| 4 | ОНХС | 476,141.6 | - | 476,141.6 | 476,141.6 | - | 476,141.6 | - | 0 |
| | **ОНБ-дын дүн** | **1,176,130.8** | **71,400.0** | **1,247,530.8** | **1,087,976.5** | **53,419.5** | **1,141,396.0** | **(106,134.8)** | |
| 5 | ЕБСургууль-1 | 1,714,606.4 | 1,350.0 | 1,715,956.4 | 1,603,350.8 | 1,350.0 | 1,604,700.8 | (111,255.6) | Төвлөрүүлсэн |
| 6 | ЕБСургууль-2 | 1,715,646.1 | 1,350.0 | 1,716,996.1 | 1,608,484.4 | 1,350.0 | 1,609,834.4 | (107,161.7) | Төвлөрүүлсэн |
| 7 | Хүүхдийн цэцэрлэг-1 | 731,535.0 | - | 731,535.0 | 685,701.7 | - | 685,701.7 | (45,833.3) | Төвлөрүүлсэн |
| 7 | Хүүхдийн цэцэрлэг-2 | 354,978.2 | - | 354,978.2 | 351,124.1 | | 351,124.1 | (3,854.1) | Төвлөрүүлсэн |
| 9 | НТБ төв | 90,457.6 | | 90,457.6 | 87,175.1 | | 87,175.1 | (3,282.5) | Төвлөрүүлсэн |
| 10 | Спорт ордон | 64,032.1 | 10,000.0 | 74,032.1 | 63,929.2 | 9,590.8 | 73,520.0 | (512.1) | Төвлөрүүлсэн |
| 11 | Соёлын төв | 105,228.8 | 4,000.0 | 109,228.8 | 100,496.9 | 4,050.0 | 104,546.9 | 4,681.9 | Төвлөрүүлсэн |
| | **ТЗШ дүн** | **4,776,484.2** | **16,700.0** | **4,793,184.2** | **4,500,262.2** | **16,340.8** | **4,516,603.0** | **(267,217.4)** | |
| | **Нийт дүн** | **5,952,615.0** | **88,100.0** | **6,040,715.0** | **5,588,238.7** | **69,760.3** | **5,657,999.0** | **(373,352.2)** | |

*Эх үүсвэр: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 69760.3 мянган төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 18339.7 сая төгрөгөөр тасарсан нь СХС-гийн зээлийн эргэн төлөлтөөс оруулах орлого, ЗДТГ өөрийн орлогын төлөвлөгөөг биелээгүйтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 54 төсөл, арга хэмжээнд 476141.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 476141.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5643705.6 мянган төгрөг нь 93.4 хувьтай байгаа нь сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн төлөвлөгөө, ЗДТГ-ын өөрийн орлого тасарсантай холбоотой байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 236920.3 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/- 275275.2, дээд шатны төсвийн захирагчаас 1600.0 үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2079.0 мянган төгрөг, хандив тусламжийн орлого 3225.2 мянган төгрөг нийт 282179.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

*Хүснэгт дугаар 10. Нэмэлт санхүүжилт* */мянган төгрөг/*

| Д/д | Байгууллагын нэр | Нэмэлт төсөв | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | НДШ листийн орлого | Бусад орлого | Нийт | |
| 1 | ЗДТГ | - | 275,500.3 | 275,500.3 | Монгол улсын тэргүүний сумын шагнал, аймгийн ХО-тын зардал |
| 2 | ИТХ | | 100.0 | 100.0 | Аймгийн ИТХ-ын шагнал |
| 3 | ЕБСургууль | | 3,579.0 | 3,579.0 | төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого , БСУГ -аас төгрөг |
| 4 | | - | - | - | |
| 5 | | | - | - | ЭМГ -аас эм бэлдмэлийн үнэ, сорьц тээврийн ажлын хөлс |
| 6 | Соёлын төв | | 3,000.0 | 3,000.0 | Хөшөөт хөгжил сангаас Тоног төхөөрөмж |
| | **Нийт дүн** | **-** | **282,179.3** | **282,179.3** | |

*Эх үүсвэр: Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үүнээс тээвэр шатахуунд 3579.0мянга, бараа үйлчилгээний бусад зардал 263930.8 мянга, нэг удаагийн шагнал урамшуулалд 100.0 мянган төгрөгийг зарцуулж 14569.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**3.7 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 138 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг байршуулаагүй байна. ОНХС-гийн гүйцэтгэл, СХС-гийн бүх мэдээлэл, ОНХС, СХС-гийн санхүүгийн тайлан, ТТЗ-ийн аудитын тайлан, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын тайлан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэрийг мэдээлээгүй байна.

**3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 129243.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2 төлбөрийн актаар 6086.3 мянган төгрөг, 123156.7 мянган төгрөгийн 16 алдаа зөрчилд зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт 50% хэрэгжсэн байна.

*Хүснэгт 11* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 6,086.3 | 0 | 3,899.3 | 2 | 2,187.0 | 64.07 |
| Албан шаардлага | | | | | 0 | - | 0 |
| Зөвлөмж | 16 | 123,156.7 | 12 | 59,947.8 | 4 | 63,208.9 | 48.68 |
| **Нийт дүн** | **18** | **129,243.0** | **12** | **63,847.1** | **6** | **65,395.9** | **50** |

Өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн 2 төлбөрийн актын 3899.3 мянган төгрөгийг бүрэн барагдуулж 2187.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй, 123156.7 мянган төгрөгийн 12 зөвлөмжөөс 4 зөвлөмжийн 63208.9 мянган төгрөгийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

## 3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 ОНӨААТҮГ нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 8 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 3 тайланг түүвэрт хамруулж 1 байгууллага итгэл авсан байна.

*Хүснэгт №12. Аудитад хамрагдсан хэлбэр, аудитын дүгнэлт*

| № | Байгууллагын ангилал, нэр | | Аудитын дүгнэлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт | Гэрээгээр хийлгэсэн | Зөрчилгүй | Хязгаарлалттай |
| 1 | Төсвийн шууд захирагч | ЗДТГ | | 1 | | | |
| 2 | | ИТХ | | 1 | | | |
| 3 | | Сургууль-1 | 1 | | | | 1 |
| 4 | | Сургууль -2 | 1 | | | | 1 |
| 5 | | Цэцэрлэг-1 | 1 | | | 1 | |
| 6 | | Цэцэрлэг-2 | 1 | | | 1 | |
| 7 | | НТБ | 1 | | | 1 | |
| 8 | | Спорт цогцолбор | 1 | | | 1 | |
| 9 | | Соёлын төв | 1 | | | 1 | |
| 10 | ОНТС | СХС | | 1 | | | |
| 11 | | ОНХС | | 1 | | | |
| 12 | ОӨААНТҮГ | Минжит булган ОНӨҮГ | 1 | | | 1 | |
| **Дүн** | | | **8** | **4** | **0** | **6** | **2** |

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Зөрчилгүй"-6, "Хязгаарлалттай" 2, нийт 8 дүгнэлт гаргасан байна.

***<u>Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар илэрсэн алдаа, зөрчил:</u>***

Аудитаар нийт 151335.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 1 албан шаардлага бичигдэж 151335.7 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

*<u>Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга</u>*

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн тайлан байхгүй байна.

***<u>Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага</u>***

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 154 мэдээллээс 138 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг байршуулаагүй байна. ОНХС-гийн гүйцэтгэл, СХС-гийн бүх мэдээлэл, ОНХС, СХС-гийн санхүүгийн тайлан, ТТЗ-ийн аудитын тайлан, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын

тайлан, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэрийг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

## ***Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн алдаа, зөрчил***

Булган сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 369767.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 161937.3 мянган төгрөгийн алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 207829.7 мянган төгрөгийн алдаа зөрчлөөс 7800.4 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд төлбөрийн акт, 180768.2 мянган төгрөгийн 3 алдаа зөрчилд албан шаардлага, 19261.0 мянган төгрөгийн 12 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт № 12. ТШЗ-ын нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн нийт алдаа зөрчил, шийдвэрлэлт /мянган.төгрөг/*

| № | Байгууллагын ангилал, нэр | | нийт илэрсэн алдаа | | Үүнээс залруулсан | | Залруулаагүй | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | **тоо** | **дүн** | **тоо** | **дүн** | **тоо** | **дүн** |
| 1 | Төсвийн шууд захирагч | ЗДТГ | - | - | - | - | 0 | - |
| 2 | | ИТХ | - | - | | | | |
| 3 | | Сургууль 1 | **4** | **35,456.6** | 1 | 3,029.0 | 3 | 32,427.6 |
| 4 | | Сургууль 2 | **6** | **229,132.7** | 1 | 154,558.3 | 5 | 74,574.4 |
| 5 | | Цэцэрлэг | **5** | **10,454.5** | 1.0 | 3,000.0 | 4 | 7,454.5 |
| 6 | | Цэцэрлэг 2 | **1** | **2,404.5** | | | 1 | 2,404.5 |
| 7 | | НТБ | **1** | **90,157.6** | | | 1 | 90,157.6 |
| 8 | | Спорт цогцолбор | **3** | **2,161.1** | 1 | 1,350.0 | 2 | 811.1 |
| 9 | | Соёлын төв | **1** | **-** | - | - | 1 | - |
| 10 | ОНТС | СХС | **-** | **-** | | | | |
| 11 | | ОНХС | **-** | **-** | | | | |
| 12 | ТБОӨААН | Минжит булган | **2** | **-** | | | 2 | |
| | | **Дүн** | **23** | **369,767.0** | **4.0** | **161,937.3** | **19** | **207,829.7** |

| № | Байгууллагын ангилал, нэр | | Залруулаагүй алдаа, зөрчил | | Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | **тоо** | **дүн** | **тоо** | **дүн** | **тоо** | **дүн** | **тоо** | **дүн** |
| 1 | Төсвийн шууд захирагч | ЗДТГ | **3** | **7,217.6** | 1 | 517.6 | - | - | 2 | 6,700.0 |
| 2 | | ИТХ | **0** | **-** | - | - | - | - | - | - |
| 3 | | Сургууль | **5** | **1,003,349.1** | 1 | 1,822.2 | 2 | 1,001,526.9 | 3 | - |
| 4 | | Цэцэрлэг | **3** | **1,224.5** | 1 | 1,224.5 | 1 | - | 1 | - |
| 5 | | ЭМТ | **0** | **-** | - | - | - | - | - | - |
| 6 | | Соёлын төв | **1** | **-** | - | - | - | - | 1 | - |
| 7 | ОНТС | СХС | **0** | **-** | - | - | - | - | - | - |
| 8 | | ОНХС | **0** | **-** | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ОНӨААТҮГ | Үенч МУБ | 1 | 6,835.0 | - | - | - | - | 1 | 6,835.0 |
| 9 | Сумын нэгтгэл | | 0 | - | | | | | | - |
| | **Дүн** | | **13** | **1,018,626.2** | **3** | **3,564.3** | **3** | **1,001,526.9** | **8** | **13,535.0** |

| № | Байгууллагын ангилал, нэр | | Залруулаагүй алдаа, зөрчил | | Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | **тоо** | **дүн** | **тоо** | **дүн** | **тоо** | **дүн** | **тоо** | **дүн** |
| 1 | Төсвийн шууд захирагч | ЗДТГ | - | - | - | - | - | - | - | - |
| 2 | | ИТХ | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | | Сургууль 1 | 3 | 32,427.6 | 1 | 2,385.1 | 1 | 26,794.5 | 1 | 3,248.0 |
| 4 | | Сургууль 2 | 5 | 74,574.5 | 2 | 5,037.9 | 1 | 63,816.2 | 2 | 5,720.4 |
| 5 | | Цэцэрлэг 1 | 4 | 7,454.5 | 1 | 377.4 | - | - | 3 | 7,077.1 |
| 6 | | Цэцэрлэг 2 | 1 | 2,404.5 | | | | | 1 | 2,404.5 |
| 7 | | НТБ | 1 | 90,157.6 | | | 1 | 90,157.60 | - | - |
| 8 | | Спорт цогцолбор | 2 | 811.0 | | | 0 | 0 | 2 | 811.0 |
| 9 | | Соёлын төв | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| 10 | ОНТС | СХС | - | - | - | - | - | - | - | - |
| 11 | | ОНХС | - | - | - | - | - | - | - | - |
| 12 | ОНӨААТҮГ | Минжит булган | 2 | - | - | - | - | - | 2 | - |
| 13 | Сумын нэгтгэл | | - | - | | | | | | - |
| | **Дүн** | | **19** | **207,829.7** | **4** | **7800.4** | **3** | **180768.3** | **12** | **19,261.0** |

## 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гүйцэтгэл, чанартай холбоотой асуудлыг цаг хугацааны хувьд газар дээр нь очиж үзэж амжаагүй болно.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **ОНХС-гийн зарцуулалттай холбоотой асуудал**

*1.1.* *<u>Илрүүлэлт:</u>* Сумын ОНХС-гийн хөрөнгийг зарцуулахдаа иргэдийн санал аваагүй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг батлуулсан, техник эдийн засгийн үндэслэлгүй, зураг төсөвгүй 15286.1 мянган төгрөгийн ажлыг ИТХ-аар батлуулж санхүүжүүлсэн, ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 50000.0 мянган төгрөгийн хашаа болон гэрэлтүүлэгийн ажлыг данс бүртгэлд бүртгээгүй, босго үнээс давсан 12000.0 мянган төгрөгийн үнэтэй лед дэлгэц худалдан авах ажилд шууд гэрээ байгуулжээ.

*1.2.* *<u>Эрсдэл:</u>* Сангийн хөрөнгийн үр өгөөж буурах, сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах

1.3. *Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалын 3.11.3-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх", 3.1.4-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад сум, дүүргийн төвөөс алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг заавал багтаах" гэсэн заалтуудыг зөрчин иргэдийн санал аваагүй, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлууд нь батлагдсан зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй байхад арга хэмжээг ИТХ-аар оруулан батлуулж зарцуулдаг байдлыг таслан зогсоох, хөрөнгөд бүртгээгүй хөрөнгийг данс бүртгэлд тусгаж босго үнээс давсан ажлыг харьцуулалтын аргаар тендер шалгаруулан ажиллах*

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

## 2 СХС-гийн зарцуулалттай холбоотой асуудал

*2.1.1 Илрүүлэлт:* СХС-гийн авлагыг данс бүртгэлд тусгахдаа зээлийн авлагыг 34943.4 мянган төгрөгөөр зөрүүтэй, малжуулах хөтөлбөрийн авлагыг 39106.2 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

*2.1.2 Эрсдэл:* Сангийн хөрөнгийн үр өгөөж буурах, сангийн хөрөнгө зориулалт бусаар зарцуулагдах, найдваргүй авлага нэмэгдэх

*2.1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг данс бүртгэлд заавал тусгана", 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж СХС анх үүссэн цагаас эхлэн анхан шатны баримт болон дансны хуулгаар зээлдэгч нэг бүрийн тооцоог дахин хянах*

*2.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:* Хүлээн зөвшөөрсөн

## 3.1 . Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал

***3.1.1. Илрүүлэлт:*** *Тайлант онд тус байгууллага нь татварын болон татварын бус орлогыг дансанд орсон мөнгөн дүнгээр нь тайлагнаж санхүүгийн албаны дарга нь өөрийн албан тушаалын тодорхойлолтод заасан зорилтыг хэрэгжүүлээгүй байна.*

***3.1.2. Эрсдэл:*** Орлогын төлөвлөгөө тасрах, татварын орлого төлөгдөхгүй байх, татвараас зайлсхийх

***3.1.3 Өгсөн зөвлөмж:*** *Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 42 тоот тогтоолын 2-р хавсралтын 1 дүгээр зорилтын 6-д "Орлогын тогтвортой бааз суурьтай болох судалгаа, мэдээллийн сан бий болгох", 2-р зорилтын 8-д "Орон нутгийн төсвийн орлогыг холбогдох байгууллага, албан тушаалтантай тооцоо нийлж...", 3-р зорилтын хүрээнд "сумын төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотойгоор татварын байцаагчийг шуурхай удирдлагаар хангах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН, иргэдтэй тооцоо нийл орлогыг бүрэн оруулахад анхаарч ажиллах.*

***3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*** *Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн*

### 4.1 . **Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

***4.1.1. Илрүүлэлт:*** *Сумын хэмжээнд худалдан авсан бараа бүтээгдэхүүн худалдан авахад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.*

***4.1.2. Эрсдэл:*** *Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх*

***4.1.3 Өгсөн зөвлөмж:*** *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28.5. "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулахад анхаарч байгууллагын удирдлага, нягтлан бодогч, Төрийн сангийн төлөөлөгч нарыг удирдлагаар хангаж ажиллах*

***4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*** *Үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрсөн*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 6 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

## 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| **Огноо:** | **Аудитын нэр:** | **Булган сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан** | **Аудитын код:** |
| **2020** | | | **ХОА-2021/11/СТА-ТТЗ** |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | **Булган сумын Засаг дарга** | **Мянган төгрөгөөр** | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| 1 | Төсвийн тухай хууль, ОНХС-гийн журам зөрчин иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй | 77286.1 | Зөвлөмж | Засаг дарга, Санхүүгийн албаны дарга | Ж.Дамдинбазар Д.Энхболд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй | 0 | Албан шаардлага | | |
| 3 | СХС-гийн авлагыг санхүүгийн тайланд зөрүүтэй нэгтгэсэн. | 74049.6 | Зөвлөмж өгөх | | |
| 4 | Санхүүгийн албаны дарга албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй | 0 | Зөвлөмж өгөх | | |
| 5 | Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн | 0 | Зөвлөмж өгөх | | |
| | **Дүн** | 151335.7 | | | |

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**